



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 57

Есөнбулаг сум

Орон нутгийн өмчийн 2016 оны дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:


1. Аймгийн 2016 оны орон нутгийн өмчийн нийт 12 494 107 017 /Арван хоёр тэрбум дөрвөн зуун ерэн дөрвөн сая нэг зуун долоон мянга арван долоон/ төгрөгийн эргэлтийн хөрөнгө, нийт 189 074 395 074 /Нэг зуун наян есөн тэрбум далан дөрвөн сая гурван зуун ерэн таван мянга далан дөрвөн/ төгрөгийн үндсэн хөрөнгийн дүнг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Өмч хөрөнгийн 2016 оны тайлан мэдээг заасан хугацаанд ирүүлээгүй, чанаргүй ирүүлсэн, захиргааны статистикийн мэдээлэл, судалгааг хожимдуулан ирүүлсэн. эд хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлдээ бүртгээгүй хоёрдугаар хавсралтад дурдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтануудад хариуцлага тооцож арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай.

3. Олон улсын болон дотоодын зээл, буцалтгүй тусламж, төсөл хөтөлбөр, бусад санхүүжилтээр эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдэд бий болсон хөрөнгийг Төсвийн тухай хуулийн дагуу Орон нутгийн өмчид бүртгэж авах ажлыг яаралтай зохион байгуулж, дүн мэдээг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 57-р тогтоолын 1-р хавсралт




ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН 2016 ОНЫ ЭРГЭЛТИЙН БОЛОН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДҮН

/төгрөгөөр/

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	2016 оны дүн
Нэг. Эргэлтийн хөрөнгө		
1.1	Мөнгө	1,464,747,302
1.2	Авлага	1,277,697,716
1.3	Бараа материал, нөөц	6,346,499,684
1.4	Бусад эргэлтийн хөрөнгө	3,405,162,315
Эргэлтийн хөрөнгийн дүн		12,494,107,017
Хоёр. Үндсэн хөрөнгө		
2.1	Барилга байгууламжийн дансны үнэ	130,986,901,622
	Хуримтлагдсан элэгдэл	57,687,384,839
2.2	Тоног төхөөрөмжийн дансны үнэ	21,117,454,796
	Хуримтлагдсан элэгдэл	12,304,149,990
2.3	Тээврийн хэрэгслийн дансны үнэ	6,997,081,270
	Хуримтлагдсан элэгдэл	3,799,306,471
2.4	Тавилга эд хогшлийн дансны үнэ	5,893,221,652
	Хуримтлагдсан элэгдэл	3,581,478,984
2.5	Түүх соёлын дурсгалт зүйлс	1,013,821,026
2.6	Ном	541,404,355
2.7	Дуусаагүй барилга, байгууламж	2,235,000,000
2.8	Бусад үндсэн хөрөнгө	19,977,273,954
	Хуримтлагдсан элэгдэл	6,841,445,854
2.9	Биет бус хөрөнгө	312,236,398
	Хуримтлагдсан элэгдэл	207,004,118
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		189,074,395,074
Нийт хөрөнгийн дүн		201,568,502,091

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 57-р тогтоолын 2-р хавсралт



ӨМЧИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА ХОЖИМДУУЛСАН БОЛОН ТАЙЛАН ЧАНАРГҮЙ ГАРГАСАН БАЙГУУЛЛАГА

Д/д	Сумын нэр	Байгууллагын нэр	Хариуцлага тооцох албан тушаалтан
1	Бигэр сум	Сум дундын эмнэлэг	Байгууллагын дарга, /эрхлэгч / нягтлан бодогч нарт
		Сургууль	
		Цэцэрлэг	
		Соёлын төв	
2	Дарив сум	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	
		Засаг даргын Тамгын газар	
		Эрүүл мэндийн төв	
3	Тонхил сум	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	
		Засаг даргын Тамгын газар	
		Эрүүл мэндийн төв	